

“Хүмүүний номын баяр хуримын дохионы тайлбар нялхсын хөг
найр” зохиолын бичвэр зүйн судалгаа

Мөнхбатын ТӨРМАНДАХ*
Монгол улс, Улаанбаатар
Гандантэгчэнлин хийд,
Монголын Бурханы Шашны Их Сургууль

Received: Jun 13, 2025 | Revised: Dec 21, 2025 | Accepted: Dec 28, 2025

Хураангуй: Монголын эрдэмтэн лам нар санскрит, төвөд хэлт ном судрыг монгол хэлэнд орчуулан, Бурханы шашны утга зохиол, гүн ухаан, сургаалын зохиол бүтээлүүдийг түгээн дэлгэрүүлэхийн зэрэгцээ төвөд хэлээр ном зохиол туурвин төвөдийн шашин, соёлд харилцан нөлөөлж ирсэн зэргээс үзвэл монголын эрдэмтэн, лам нар төвөд хэлийг ахисан түвшинд суралцдаг байсан нь тодорхой байна. Монголын нэрт эрдэмтэн Алшаа Агваандандар лхаарамбын (1759-1840) туурвисан “Хүмүүний номын баяр хурим” зохиол нь Төвөд хэлний хуучин үг хэллэг, илт өгүүлэх нэр, хүндэтгэлийн нэр болон нутгийн үг хэллэг зэрэг нэр томъёог түлхүү ашигласан нь их хүрээний уламжлалт нэр орчуулгын хичээл буюу төвөд хэлнээс монгол хэлэнд орчуулгын хичээлд “Нэрийн арван бага” эмхэтгэлийн голлох бүтээл болгон судалдаг байжээ.

Энэ бүтээлийг үе үеийн эрдэмтэн мэргэд судалж, уг зохиолын бэрх үгийн тайлбар болсон дохионы тайлбар (мө: *brda bkrol*), түүвэр нэр (мө: *btus ming*), орчуулга зэрэг олон тайлбар зохион туурвисны дотроос “Хүмүүний номын баяр хуримын дохионы тайлбар нялхсын хөг найр” (мө: *blabs bya mi chos dga' ston gyi brda' bkrol byis ba'i rol rdzod*) сонирхол татна.

Уг тайлбарын зохиогч Лоданы (мө: *blo ldan*) намтар тодорхойгүй боловч бид энэхүү ажлаараа түүний намтартай холбоотой зарим мэдээг “Хүмүүний номын баяр хуримын дохионы тайлбар нялхсын хөг найр” нэрт дохионы тайлбараас тодруулах, “Хүмүүний номын баяр хурим” зохиолын 600 орчим бэрх үгийг тайлбарлахдаа ашигласан эшлэл, ном зүй болон зарим үгийг Монгол, Хятад хэлэнд орчуулж төвөд үсгээр галиглан бичсэн зэргийг танилцуулж байна.

Түлхүүр үг: Дохионы тайлбар, Алшаа Агваандандар лхаарамба, Хүмүүний номын баяр хурим, Лодан

* © М.Төрмандах
Email: l.rikchok@gmail.com

Textual Study of the Work "Decipher of Fest of Human Virtual-Celebration of Newborn"

TURMANDAKH Munkhbat
Mongolian Buddhist University,
Gandantegchenlin monastery,
Ulaanbaatar, Mongolia

Abstract: *Mongolian scholar-monks not only translated Sanskrit and Tibetan texts, sutras, and literary works into Mongolian, thereby disseminating Buddhist literature, philosophy, and teachings to the Mongolian people, but they also composed scholarly works in the Tibetan language, influencing Tibetan religion and culture. This indicates that Mongolian scholar-monks had an advanced proficiency in the Tibetan language. The "The Fest of human ritual," authored by the renowned Mongolian scholar Alxa Agvaandandar Lharamba (1759-1840), uses a significant number of archaic terms of Tibetan, synonyms, honorific terms, and regional dialects, making its terminology rare and complex. As a result, it was considered a core literary text within the traditional Mongolian Ih Khuree curriculum, specifically the "Ten Minor literary" compilation, which taught translation from Tibetan into Mongolian.*

Over generations, scholars have studied this work and created numerous commentaries and translations, including "brda bkrol" (decipher of terms) and "btus ming" (collection of terms), which serve as glossaries for the difficult terms in the text. Among these commentaries, "Decipher of Fest of Human Virtual-Celebration of newborn" (tib: blabs bya mi chos dga' ston gyi brda' bkrol byis ba'i rol rdzod) by Lodan is particularly intriguing.

The author of this commentary, Lodan (tib: blo ldan), remains biographically elusive. However, through "Decipher of Fest of Human Virtual-Celebration of newborn", we aim to clarify certain details related to his life by drawing upon his commentary. Furthermore, we present the bibliographic sources used to explicate approximately 600 difficult words within the main work and words that have been translated into Mongolian and Chinese using Tibetan transliteration.

Key words: *Decipher of Code, Alshaa Agvaandandar lhaaramba, Fest of human virtual, blo ldan,*

1. Удиртгал

Монголын эрдэмтэн лам нар санскрит, төвөд хэлт ном судрыг монгол хэлэнд орчуулан, Бурханы шашны утга зохиол, гүн ухаан, сургаалын зохиол бүтээлүүдийг түгээн дэлгэрүүлэхийн зэрэгцээ төвөд хэлээр ном зохиол туурвижээ. Эртний Энэтхэгийн уудалж баршгүй уран зохиолын соёлын өв, Цастан Төвөдийн элдэв сонин түүх зохиолуудыг монголчууд маань орчуулах, дахин найруулан зохиох, төвөд, монгол хоёр хэлээр зохион бичих зэргээр өөрийн болгон хүлээн авах явц дунд монгол уран зохиолынхоо хөгжлийг урагш ахиулсаар иржээ. Энэхүү бэрхшээлтэй хүндтэй үүргийг ихэвчлэн бурхан шашны үнэнч зүтгэлтэн болсон монгол лам эрдэмтэд биелүүлсэн юм.

Төвөд орныг зорин бурхны шашны эрдэм мэдлэгийн дээдэд хүрч, их бага ухаанд нэвтэрсэн мэргэд олон гарч тэдгээрийн дотроос төвөд хэлээрээ зохиол бүтээлээ туурвисан монгол эрдэмтдийг монголчууд байтугай төвөдүүд өөрсдөө үзэн судалж гайхан магтдагийн нэгэн төлөөлөгч бол Алшаа лхаарамба, Дандар лхаарамба, Алшаа Агваандандар лхаарамба, Лхадан Монлам равжамба Агваандандар зэрэг нэрээр олноо алдаршсан Алшаагийн Агваандандар лхаарамба юм. Тэрээр нэгэн насаа монгол, төвөдийн ард түмний соёл гэгээрэлд

зориулсан, буддын гарамгай гүн ухаантан, хэл шинжээч, яруу найргийн онолч, шашны зүтгэлтэн хүн тул зохиол бүтээл нь Монгол орноо төдийгүй төвөдүүдийн дунд ч өргөн тархсан билээ.

1959 онд Олон улсын монголч эрдэмтдийн анхдугаар их хуралд МБШТөв-Гандантэгчэнлин хийдийн XXV хамба номун хан, номч мэргэн гавж Самаагийн Гомбожав “Монголчуудын төвөд хэлээр зохиосон зохиолын зүйл” хэмээх илтгэл хэлэлцүүлэхдээ “Агваандандар лхаарамбын талаар дурдсан бөгөөд, тус өгүүллийнхээ дагалдуулал болгож хэвлүүлсэн бүртгэлийн долоодугаарт “Агваандандар лхаарамба Алшаа хошуу, арван наймдугаар зууны үеийн хүн, бүх зохиол нь хоёр боть, судар, тарнийн тайлбар, дуун ухааны онол зэрэг. Гүмбүмд бартай” (Гомбожав, 1961:26) хэмээн олон нийтэд мэдээлжээ. Мөн Ч.Алтангэрэл гуайн “Монгол зохиолчдын төвөдөөр бичсэн бүтээл” (1967), М.С.Өлзий профессорын “Дайчин гүрний монголчуудын төвөд уран зохиолын судлал” (2014), Р.Бямба ламын “Монголчуудын төвөд хэлээр туурвисан монгол хэлэнд орчуулсан ном зүйн бүртгэл” (2004), Г.Цогт “Алшаа лхаарамба Агваандандарын зохиолын чуулган” (2014), “Алшаа Агваандандарын өгүүллийн чуулган” гурван дэвтэр (1999) зэрэг нь эл чиглэлийн судалгаанд чухал гарын авлага болсоор байна.

Их хүрээний уламжлалт сургалтад нэр орчуулга буюу төвөд хэлнээс монгол хэлэнд орчуулж сурахад “Нэрийн арван бага” хэмээн нэрт сургаалын зохиолын эмхэтгэлийг судалдаг бөгөөд багшаас шавьд аман уламжлалаар дамжин заадаг байжээ. Эдгээрийн дундаас Алшаа лхаарамба Агваандандарын “Суртгаал хүмүүний номын баяр хурим” (тө: slab bya mi chos dga' ston) нь дээд монголын нэрт эрдэмтэн Агваанчойдорын тэмдэглэснээр “Хуучин ном дээр гардаг хатуу хэл, захидлын хүндэтгэлийн үг буюу зарлиг буулгахад онцгой хэрэглэдэг үг зэргийг монгол хүн бүү хэл, төвд хүн ч ойлгоход бэрх байдаг. Агваандандар лхаарамба тэр бүхнийг цуглуулж ийм ном (“Хүмүүний номын баяр хурим”)-ыг бүтээсэн нь бидэнд их тус хүрч байна” (Агваанчойдор, 2009: 130) хэмээн энэхүү зохиолд төвөдийн хуучирсан үг хэллэг, захиа бичгийн хүндэтгэлийн үг хэллэг зэрэг орчуулахад хүнд хэцүү үг хэллэгийг холин сүлж бичсэн зохиол гэдгээрээ онцлог болохыг анзааран тэмдэглэн тодорхойлсон байна.

Энэхүү үе үеийн эрдэмтэн мэргэдийн анхаарлыг ихэд татсан “Хүмүүний номын баяр хурим” хэмээх зохиол нь яруу найраг, эвсүүлэн найруулах арга зэргийг ашиглан 100 шүлэг буюу 400 мөр, нэг мөрөнд 9 үе (тө: tseg bar)-ээр жигдэлсэн шүлэглэсэн сургаалын зохиол ба энэхүү зохиол нь бидний тооцоолж гаргаснаар төгсгөлийн үгтэйгээ нийлээд 3916 үеэс бүрдэх нийт давхардсан тоогоор 2557, давхардаагүй тоогоор 2000 орчим үгтэй байна.

Энэ бүтээлийг эртнээс уламжлагдан ирсэн уламжлалт нэр орчуулгын хичээл, сургалтад голчлон ашиглаж, тухайн зохиолд дохионы тайлбар (тө: brda bkrol), түүвэр нэр (тө: btus ming) зэрэг үгийн тайлбарыг олонтоо хийж байсан талаар Р.Бямбаа “Уг зохиолд буй бэрх үг болон төвөдийн ярианы хэлнээс авсан үг хэллэгийг нь тайлбарласан “Дадал /brda' dkrol/”, “Дүймин /bdus ming/” нэртэй тайлбарууд олон байдаг. Жишээлбэл: “bslab bya mi chos dga' ston gyi brda' bkrol nges tshig rab tu 'byed pa”, 12 хуудастай, “bslab bya mi chos dga' ston gyi brda' bkrol byis ba'i rol rdzod ces bya ba”, 30 хуудастай, “bslab bya mi chos dga' ston gyi brda' bkrol blo ldan dga' bskyes ces bya ba” 14 хуудастай гэх мэт” (Бямбаа, 2004: 536) хэмээн мэдээлжээ.

Эдгээр бэрх үгийн тайлбар зохиол дундаас “Суртгаал хүмүүний номын баяр хуримын дохионы тайлбар нялхсын хөг найр” (тө: blabs bya mi chos dga' ston gyi brda' bkrol byis ba'i rol rdzod ces bya ba) зохиол бусад дохионы тайлбараас илүү дэлгэрэнгүй бөгөөд олон үгийг тайлбарласнаараа онцлог байна.

3. Судалгааны арга, хэрэглэгдэхүүн

Уг дохионы тайлбарын эх нь бар болон гар бичмэл эх МБШТөв-Гандантэгчэнлин хийдийн номын сан, Үндэсний номын сангийн төвөд номын сан хөмрөг, BDRC цахим номын сан, хувь хүмүүсийн цуглуулгад хадгалагдаж байна. Үүнд:

[Бар] “Хүмүүний номын баяр хуримын дохионы тайлбар нялхсын хөг найр”

Урт модон бар, судар 30х., 51x10.5 (40.5x8) 6 мөр, муутуу цаас, хар бэх.

[Нүүр] blabs bya mi chos dga' ston gyi brda' bkrol byis ba'i rol rdzod ces bya ba bzhugs so/

Зах.гарч: mi chos brda'

BDRC: W1NLM1361

[Гар бичмэл-1] “Хүмүүний номын баяр хуримын дохионы тайлбар нялхсын хөг найр”

Гар бичмэл, судар, 24 хуудас, 51x10.5 (40.5x8), 7 мөр, муутуу цаас, хар бэх

[Нүүр] blabs bya mi chos dga' ston gyi brda' bkrol byis ba'i rol rdzod ces bya ba bzhugs so/

[Гар бичмэл-2] “Хүмүүний номын баяр хуримын дохионы тайлбар нялхсын хөг найр”

Гар бичмэл, судар, 30 хуудас, 45.5x13 (36.5x8), 8 мөр, муутуу цаас, хар бэх

[Нүүр] blabs bya mi chos dga' ston gyi brda' bkrol byis ba'i rol rdzod ces bya ba bzhugs so/

BDRC: W1NLM6170

ҮНС: M0064088-001

Бид энэхүү судалгааны ажлаар уг гурван эхээс барын эхийг гол хэрэглэгдэхүүнээ болгон уг зохиолын мэдээ, баримт, тайлбар зэрэгт тулгуурлан задлан шинжилж, улмаар аргаар судлах юм.

4. Судалгааны хэсэг

“Хүмүүний номын баяр хуримын дохионы тайлбар нялхсын хөг найр”-ын зохиогчийн тухай тус зохиолын төгсгөлийн үгэнд дурдсан байна. Үүнд:

“Тэр мэт дохионы тайлбар үйлдэгч

Мөхөс Лодан нэрт бөгөөд

Алдаа байваас мэргэдэд наманчилмуу

Буянаар чадагчийн шаашин дэлгэрэх болтугай”

(mө: de ltar brda' bkrol byed pa po/ /

gyi na blo ldan ming can te/ /

nongs pa srid na mkhas la chags/ /

dge bas thub bstan rgyas gyur cig // /) (Лодан, 30b) хэмээснээс үзвэл Лодан нэрт эрдэмтэн

бичсэн байна. Зохиогчийн намтар нь одоогоор бидэнд тодорхойгүй байгаа боловч уг дохионы тайлбараас үзвэл Ажаа Ёнзон, Жанжаа хутагт, Алшаа лхаарамба, Гүнтэн гэгээн, Түган ринбүүчи зэрэг эрдэмтэд тус тус “ийнхүү айлдсан, хэмээн айлдсан, хэмээн ярьсан” гэх зэрэг аман эшлэлийн хэв шинжтэй бичвэрийг оруулсан байгаа нь эдгээр эрдэмтэн лам нартай уулзаж байсан байх магадлалтай байна. Үүнээс Алшаа лхаарамба нь Алшаа Агваандандар лхаарамба (1759-1840), Ажаа Ёнзон нь Ажаа Ёнзон Лувсандондов (1740-1827) гэх эрдэмтэд гэдэг нь баттай боловч Жанжаа хутагт, Түган ринбүүчи, Гүнтэн гэгээн зэрэг нь чухам хэддүгээр дүрийн хутагт вэ? гэдэг нь тодорхойгүй байна. Мөн уг зохиолын 29-р талд “Миний багш эрдэнийн айлдсан “Хэлний зулын дохионы тайлбар элдвийг тодруулагч”-м” (mө: dbag gi bla ta rin po che'i ngag sgron gyi brda' bkrol sna tshogs gsal ba las gsungs so) (Лодан, 29b) хэмээн бичсэн “Хэлний зулын дохионы тайлбар элдвийг тодруулагч” хэмээх зохиолын зохиогч нь Сумади Авхаяа шасана дхваза (ca: sumati abhyā śāsana dhvaja, тө: su ma ti a b+h+ya shA sa na s+ya d+h+wa dza) буюу Чин сүзэгт номун ханы гуравдугаар дүр Лувсанжигмэдданбийжалцан (1829-1882) юм. Үүнээс үзвэл тухайн цаг үе буюу XIX зууны үеийн хүн бөгөөд Баянхонгор аймгийн галуут сум Чин сүзэгтийн хүрээ, Өвөр монгол зэрэг газар нутгаар амьдарч байсан хүн байх магадлалтай.

Тус зохиолын тахилын шүлэг:

“Гурван аврал бүхэн хурсан язгуур, дамжлагын багш лугаа
Ялгал үгүй зөөлөн итгэлт эцэг богдын өлмийн тоос
Зулайн орой болон зүрхний дусал дор
Байгуулан их бишрэлээр мөргөмүй.

Их амгалант номын лагшны уужим тэнгэрийн өмнө
Гайхамшигт таалал энэрлийн буман үүл тогтоод
Гүн дэлгэрэнгүй номын үүлсийн шим үргэлж буулгаснаар
Миний оюуны газарт тэвчил онолын жилийн үр төрмүй.

Үүнд ухааны орны далайн эрхшээлийн эзэн Алшаа лхаарамба ринбүүчийн зохиосон “Суртгаал хүмүүний номын баяр хурим”-ын зарим дохио утга бичихүй дор” хэмээгээд тус зохиолын 600 орчим үгийг тайлбарлахдаа Нэвтэрхий толийн аргаар тухайн үгийг тайлбарлан Ажаа Ёнзон Лувсандондов, Жанжаа хутагт Ишданбижалцан, Алшаа Агваандандар лхаарамба, Гүнтан Гончогданбидонмэ зэрэг эрдэмтдээс аман тайлбар болон энэтхэг, төвөд, монголын олон эрдэмтний бүтээлээс эшлэл, тайлбар сэлтийг аван бичсэн байна. Эдгээрийг жагсаавал:

Нэг. Энэтхэг мэргэдийн бичсэн бүтээл:

1. Амарсимха (ca: amara siṅha, тө: ‘chi med seng+ge), “Үхэл үгүйн сан” (ca: amara koṣa, тө: ‘chi ba med pa’i mdzod)
2. Арьяа Шүүрья (ca: āryaśūra, тө: slob dpon dpa’ bo), “Багшийн тавин бадагт” (ca: guru pañca biśika, Тө: bla ma lnga bcu pa)
3. Васубанду, (ca: vasubandhu, тө: dbyig gnyen), “Төв хязгаарыг сайтар ялгагчийн тайлбар” (Ca: madhyānatagatīka, Тө: dbus dang mtha’ nam par ‘byed pa’i ‘grel pa)
4. Гүнапрабха (ca: guṇaprabha, тө: yon tan ‘od), “Винайн судар” (ca: vinaya sūtra, тө: ‘dul ba’i mdo)
5. Дандин (ca: daṇḍin, тө: slob dpon dbyug pa can), “Зохист аялгууны толь” (ca: kāvyādarśa, тө: snyan ngag me long)
6. Дигнага (ca: dignāga, тө: slob dpon phyogs glang), “Шалгадаг бүхний хураангуй” (ca: sarvapramāṇasiddhi, тө: tshad ma kun las btus pa)
7. Майдар (ca: maitreya, тө: byams pa), “Билгүүний чанадад хүрэхүйн увдис шастир илт онохуйн чимэг” (ca: abhisamyaḷaṃ kāraṇāma prajñāpāramitā upadeśaśāstra, тө: shes rab kyī pha rol tu phyin pa’i man ngag gi bstan bcos mngon par rtogs pa’i rgyan)
8. Нагаржуна (ca: nāgārjuna тө: mgon po klu sgrub), “Саданд илгээсэн захидал” (ca: suhridālekh , тө: bshes pa’i spring yig)
9. Чандрагирди (ca: candrakīrti, тө: dpal ldan chos grags), “Дундад орохуй” (ca: madhyamaka avatāra, тө: dbu ma la ‘jug pa)
10. Чандрагомин (ca: candragomin, тө: zla ba’i ‘od), “Шавьд илгээсэн захидал” (ca: shikṣālekha, тө: slob ma la springs pa’i spring yig)
11. Шагжамүни будда (ca: śakyamuni buddha тө: ston pa sha kyA thub pa), “Хутагт сайн явдлын ерөөлийн хаан” (ca: aryabhadratsarya prañidhādhānarāja, тө: ‘phags pa bzang po spyod pa’i smon lam gyi rgyal po)
12. Шагжамүни будда (ca: śakyamuni buddha тө: ston pa sha kyA thub pa), “Хутагт бүдүүн чимэг байгуулсан судар” (ca: aryaghana juyuhana mahayana sutra, тө: ‘phags pa bzang po spyod pa’i smon lam gyi rgyal po)
13. Шагжамүни будда (ca: śakyamuni buddha тө: ston pa sha kyA thub pa), “Ангид гэтлэхүйн судар” (ca: pratimokṣātra, тө: ‘phags pa bzang po spyod pa’i smon lam gyi rgyal po)
14. Шагжамүни будда (ca: śakyamuni buddha тө: ston pa sha kyA thub pa), Хутагт их үүл хэмээгдэх их хөлгөн судар (ca: āryamahārganāmahāyānasūtra, тө: ‘phags pa sprin chen po zhes bya ba theg pa chen po’i mdo)

15. Шагжамүни будда (ca: śakyamuni buddha тө: ston pa sha kyA thub pa), “Хутагт ихэд тонилгогч зүүд дор дэлгэрсэн гашуудан гэмшихүйгээр хилэнцийг арилгаад бурхан болгон бүтээхүйд тийн бөгөөд зохиосон нэрт их хөлгөн судар” (ca: āryaghanjāmahātbhija phulukārmābhīraṇa śodhāyābhudhadharabhuhānamahāyānasūtra, тө: 'phags pa thar pa chen po phyogs su rgyas pa 'gyod tshangs kyis sdig spyangs te sangs rgyas su 'grub par rnam par bkod pa 'i mdo)
16. Шагжамүни будда (ca: śakyamuni buddha тө: ston pa sha kyA thub pa), “Хутагт сайн бэлгэт хэмээгдэх судар” (ca: āryabhadrakarātrīnāmasūtra, тө: 'phags pa mtshan mo bzang po zhes bya ba'i mdo)
17. Шагжамүни будда (ca: śakyamuni buddha тө: ston pa sha kyA thub pa), “Хутагт долоон түүнчлэн ажирсны дэлгэр ялгамжаа хэмээгдэх их хөлгөн судар, Эмийн судар найман зууг” (ca: ārya sabta tathāgata pūrba praṇidhāna biśeṣabi stāra nāma mahāyāna sūtra, тө: 'phags pa mtshan mo bzang po zhes bya ba'i mdo 'phags pa de bzhin gshegs pa bdun gyi khyad par rgyas pa zhes bya ba theg pa chen po'i mdo/ sman mdo brgyad brgya ba)
18. Шагжамүни будда (ca: śakyamuni buddha тө: ston pa sha kyA thub pa), “Хутагт номыг үнэмлэхүй хураасан хэмээгдэх их хөлгөн судар” (ca: āryadharmasangitīnamamahāyānasūtra, тө: 'phags pa chos yang dag par sdud pa zhes bya ba theg pa chen po'i mdo)
19. Шантидэва (ca: śāntideva, тө: zhi ba lha), “Бодьсадвын явдалд орохуй” (ca: bodhisattvacāryāvātāra, тө: byang chub sems dpa'i spyod pa la 'jug pa)
20. Харибадра (ca: haribhadra, тө: seng+ge bzang po), “Билгүүний чанадад хүрэхүйн увдис шастир илт онохуйн чимэг хэмээгдэхийн тайлбар” (ca: abhisamaya alaṅkāra nāma prajñā pāramita upadeśa śāstra br̥tti, тө: shes rab kyi pha rol tu phyin pa'i man ngag gi bstan bcos mngon par rtogs pa'i rgyan zhes bya ba'i 'grel ba)
21. Харибадра (ca: haribhadra, тө: seng+ge bzang po), “Хутагт билиг билгүүний чанадад хүрэхүйн найман мянгатын номлол илт онохуйн чимгийн гэгээ”, (ca: āryaprajñāpāramitāśādasahasrikabyakhyānābhisamayālaṅkāralokānāma, тө: 'phags pa shes rab kyi pha rol tu phyin pa brgyad stong pa'i bshad pa mngon par rtogs pa'i rgyan gyi snang ba)

Хоёр. Төвөд мэргэдийн бичсэн бүтээл:

1. Янжандүвбийдорж, “Нэг нэр олон утгад орох ёсны номлол саруул оюунтны хоолойн чимэг” (тө: ming gcig don mang po la 'jug tshul bshad pa blo gsal mgrin rgyan)
2. V Далай лам Агваанлуvsанжамц, “Хос ёсны суртгаал улаан сувдан эрих” (тө: lugs zung gi gslab bya mu thi le'i phreng ba)
3. V Далай лам Агваанлуvsанжамц, “Винайн зан үйл тийн ялсан алтан шаргал” (тө: 'dul ba'i las chog rnam rgyal gser mdog)
4. Гарма лозава Ринчэндаш, “Төвөд хэлний шинэ хуучин дохионы ялгамжааг үзүүлсэн сайтар номлол лишийн орд харш” (тө: bod kyi skad las gsar rnying gi brda'i khyad par ston pa legs par bshad pa li shi'i gur khang)
5. Шалу лозава Ринчэнчойжонсанбуу, “Төвөдийн дохионы шастир сайтар номлолын эрдэнийн охь хайрцгийг байгуулсан хэмээгдэх” (тө: bod kyi brda'i bstan bcos legs par bshad pa rin po che'i za ma tog bkod pa zhes bya ba)
6. Хайдүвгэлэгбалсанбуу, “Дэлгэрэнгүй шастир Шалгадагийн тийн тайлбарын дэлгэрэнгүй номлол нотолгооны далай” (тө: rgyas pa'i bstan bcos tshad ma rnam 'grel gyi rgya cher bshad pa rigs pa'i rgya mtsho)
7. Хайдүвгэлэгбалсанбуу, “Цогт төгөлдөр гурван газартан” (тө: dpal ldan sa gsum ma)

8. Хайдүвгэлэгбалсанбуу, “Цогт цагийн хүрдний тайлбар хиргүй гэрлийн агуу их номлол мөн чанарыг гийгүүлэгч” (тө: dpal dus kyi ‘khor lo’i ‘grel chen dri ma med pa’i ‘od kyi rgya cher bshad pa de kho na nyid snang bar byed)
9. Сажа бандида Гунгаажалцан, “Үгийн сан” (тө: tshig gi gter)
10. Балхан лозава Агваанчойжижамц, “Төвөдийн дохионы өвөрмөц зүйлийг тодруулагч шастир үг бүлэглэсэн мэргэдийн хэлний зул” (Тө:bod kyi brda’i bye brag gsal bar byed pa’i bstan bcos tshig le’ur byas pa mkhas pa’i ngag gi sgron ma)
11. Богд Зонхава Лувсандагва, “Онол өгүүлэхийн сайн хүслэнт” (тө: rtogs brjod ‘dun legs ma)
12. Богд Зонхава Лувсандагва, “Магтаал адистид ойр оруулагч” (тө: bstod pa byin rlabs nyer ‘jug ma)
13. Бромдонжалвийжуннай, “Жовожэ гэгээний магтаал Хотол чуулсан эх” (тө: jo bo je’i bstod pa phun sum tshog pa ma)
14. Сэрдог банчэн Шагжачогдан, “Дохионы орны ялгамжааг онож үйлдэгч хэмээгдэх үгээр бүлэглэн үйлдсэн” (тө: brda’i gnas bye brag rtogs byed ces bya ba’i tshig le’u byas pa)
15. Чой-Агваан, “Шинэ, хуучин дохионы тийн агуулга” (тө: mkhas pa’i dbang po chos ngag dbang gi brda gsar rnying gi nam bzhang)
16. VII далай лам Галсанжамц, “Ялгуулсан бүгдийн таалал, энэрэл, чадал гурвын мөн чанарт гэтэлгэгч их Богд Зонхавад мэргээдийн соёрхол лугаа барилдсан багшийн егүээр Дүшидийн зуун тэнгэрийн хөтөлбөр шид бүтээл бүхэн гарвал” (тө: rgyal ba kun gyi mkhyen brtse nus gsum gyi bdag nyid rje bdzun tsong kha pa chen po la dmigs brtse ma’i gsol ‘debs dang ‘brel ba’i bla ma’i rnal ‘byor dga’ ldan lha brgya ma’i khrid yig dngos grub kun ‘byung)
17. Сажа бандида Гунгаажалцан, “Сайтар номлол эрдэнийн сан субашид хэмээгдэх шастир” (тө: legs par bshad pa rin po che’i gter zhes bya ba’i bstan bcos)
18. Дхармабадра, “Винайн далайн шимийн тайлбар сайн оюунтны тааллын утгыг тодруулагч наран” (тө: ‘dul ba rgya mtho’i snying po’i Tik blo bzang dgongs don gsal ba’i nyen byed)

Гурав. Монгол мэргэдийн бичсэн бүтээл:

1. Алшаа Агваандандар лхаарамба, “Үсгийн номлол мэргэдийн амны чимэг” (тө: yi ge’i bshad pa mkhas pa’i kha rgyan)
2. Алшаа Агваандандар лхаарамба, “Тогтсон даяг эрхэмлэн хураасан эндүүрлийг тэвчигч сайтар номлолын шинэ үүрийн гэгээ” (тө: dag yig gces bsdus ‘khrul spong legs par bshad pa’i skya rengs gsar ba)
3. Алшаа Агваандандар лхаарамба, “Нэр утгыг тодотгогч сарны гэгээн гэрэл хэмээгдэх дохионы бичиг” (тө: brda’ yig ming don gsal bar byed pa’i zla ba’i ‘od snang)
4. Ажаа Ёнзон Лувсандондов, “Хөх судрын нэр, дохио ойлгоход бэрх заримын тайлбар сэжгийн харанхуйг арилгагч” (тө: be’u bum sngon po’i ming brda go dka’ ba ‘ga’ zhig bshad pa som nyi’i mun sel)
5. Ажаа Ёнзон Лувсандондов, “Анхан оюун судлахуйн асуулт хариулт дохио утгыг тодруулагч толь” (тө: thog mar blo sbyong gi dris lan brda don gsal ba’i me long)
6. Ажаа Ёнзон Лувсандондов, “Үлгэрийн ном эрдэнэ цогцолсны дохионы тайлбар тусыг чухалчлах сэтгэлийн баяр хурим” (тө: dpe chos rin chen spungs pa’i brda bkrol don gnyer yid kyi dga’ ston)
7. Ажаа Ёнзон Лувсандондов, “Их бодь мөрийн зэргээс гарсан дохионы тайлбар чухал хэрэгцээтэйг хураасан” (тө: byang chub lam gyi rim pa chen po las byung ba’i brda bkrol nyer mkho bsdus pa)

8. Ажаа Ёнзин Лувсандондов, “Анхан оюунаа судлахуйн асуулт хариулт дохио утгыг тодруулагч толь” (тө: thog mar blo sbyong gi dris lan brda don gsal ba'i me long)
9. Ажаа Ёнзин Лувсандондов, “Эрдэнийн сан Субашидын зарим нэг дохио утга зармыг тайлбарлахуй” (тө: sa skya legs bshad kyi brda don 'ga' zhig dgrol ba)
10. Бигчү чанди (тө: b+hik+Shu k+Shan+ti), “Бигчүчандийн аман туурвилаас суртгаал хүмүүний номын баяр хурмын дохионы тайлбар оюун төгсийн баяслыг үүсгэгч” (тө: b+hik+Shu k+Shan+ti'i ngag rtsom las bslab bya mi chos dga' ston gyi brda bkrol blo ldan dga' bskyed ces bya ba bzhugs so)
11. Чин сүзэгт Лувсанжигмэдданбийжалцан, “Дохионы тайлбар хэлний зулаас гарсан нэр, утга ойлгоход бэрх нугуудын сайтар айлдсан элдвийг тодруулагч” (тө: brda'i bstan bcos ngag gi sgron ma las byung ba'i ming brda go dka' ba rnams rnam par bshad pa sna tshogs gsal ba)

Зохиогч нь тодорхойгүй

1. “Гучит, тэмдгийн орлогын тайлбар” (тө: sum rtags kyi 'grel pa)
2. “Өчүүхэн үгт” (тө: phran tshig)
3. “Шинэ хуучин дохио” (тө: brda gсар rnying)
4. “Билиг барамидын хураангуй шударга” (тө: phar phyin bsдus pa drang pa)
5. “Бодисадва унал наманчлахуйн зан үйл ганга мөрний урсгал” (тө: byang chub ltung bshags kyi cho ga gang+ga'i chu rgyun)
6. “Далайн тайлбар” (тө: mtsho TI ka)

Энэтхэг-21, Төвөд-18, Монгол-11, зохиогч нь бидэнд олдоогүй 6 зохиол буюу нийт 56 зохиолоос эшлэн тайлбараа баяжуулан судалсан байгаа нь уг бүтээлийн чанар чансаа өндөр болохыг илэрхийлэх бөгөөд мөн бар болгон хэвлэсэн зэрэг нь олон хүн сонирхож байсны нотолгоо юм.

Дээрх бүтээлүүдээс дараах байдлаар эшлэл авсан байна.

1. Тухайн үг бусад зохиолд хэрхэн ашиглагдсан байдал.

bsnyengs bral нь аюулаас хагацсан бөгөөд bsnye ba болон bsnyengs pa нь аюулын нэр гэж айлдсан. “Саданд илгээсэн захидал”-аас “**bsnyengs dang bral la mang du gsol ci 'tshal/ /**” “Аюулаас хагацсан олон дор соёрхол юу хүсэв” хэмээн айлдсан мэт. (тө: bsnyengs bral ni 'jigs bral te/_ bsnye ba'am bsnyengs pa ni 'jigs pa'i ming du bshad pa dang /_/ bshes springs las/_ bsnyengs dang bral la mang du gsol ci 'tshal/_ zhes gsung pa lta bu'o/_ /) (Лодан, 1b)

gdas pa нь өгүүлэх, айлтгах, ойлгох бөгөөд “Багшийн тавин бадагт”-ээс tshig dag gis ni **gdas par** bya/_ / “Үгээр өгүүлж үйлдье” хэмээн айлдсан мэт. (тө: gdas pa ni smra ba'am zhus sam zhu'am go ba ste/_ bla ma lnga bcu pa las/_ tshig dag gis ni gdas par bya/_ / zhes gsungs pa lta bu'o/_ /) (Лодан, 2b)

snyod pa нь өгөх, ба тэжээхийн утгатай бөгөөд “Бодисадвын явдалд орохуй”-аас “lus 'di **bsnyod** kyang gzhan 'gro na/_ /” “Энэ биеийг төлжүүлсэн ч бусдад одох тул” хэмээх ба “Хөх судрын дохионы тайлбар сэжгийн харанхуйг арилгагч”-аас “bsnyod pa нь хоол өгөх ба идэхэд оруулах” хэмээн айлдсан мэт. (тө: snyod pa ni ster ba dang gso ba'i don te/_ spyod 'jug las/_ lus 'di bsnyod kyang gzhan 'gro na/_ / zhes dang /_ be'u bum sngon po'i brda' bkrol som nyi'i mun sel las/_ bsnyod pa ni kha zas ster ba'am zar bcug pa/_ zhes gsungs pa lta ro/_ /) (Лодан, 3b) г.м

2. Тухайн үгийг бусад толь болон тайлбар зохиолд хэрхэн тайлбарлагдсан байдал

rnams нь олон тоо заасан үг бөгөөд “Гучит, тэмдгийн орлогын тайлбар”-аас “dag /zung /_ cha нугууд нь хос тооны үг. rnams/_ sogс/_ yongs/_ thams cad/_ kun/_ mtha' dag /cog /_ ma lus нугууд нь олон тооны үг ба” хэмээсэн. “Үсгийн номлол мэргэдийн амны чимэг”-ээс “1-ийг 'di, 2-ыг de dag, 3-аас дээшхийг de rnams хэмээдэг” хэмээн айлдсан мэт. (тө: rnams ni mang tshig ste/_ sum rtags kyi 'grel pa las/_ dag /zung /_ cha rnams ni gnyis tshig go/_ rnams/_ sogс/_ yongs/_ thams cad/_ kun/_ mtha'

dag /cog /ma lus rnam ni mang tshig dang /_zhes dang /_yi ge'i bshad pa mkhas pa'i kha rgyan las/_gcig la 'di/_gnyis la de dag/_gsum yan la de rnam zhes bya zhing /_zhes gsungs pa ltar ro/_/) (Лодан, 1b)

rna ba blogs нь чихээ тушаах бөгөөд “Саруул оюунтны хоолойн чимэг”-ээс “rna ba byo болон blogs pa нь чихээ тушаах” хэмээн гарсан. Үүнээс rna ba byo ba нь чих тавих бөгөөд “Өчүүхэн чуулган”-аас “Тэр дууг сонсох ба тэдгээрт чих тавих бөгөөд түр зур суух” хэмээн айлдсан. Мөн byo ba нь юүлэх буюу үхэн егүүтэх гэхэд мөн ордог бөгөөд “Хумх дүүргэн юүлэх ёсонд” хэмээх мэт. Үүнд blogs хэмээх нь захирах хүсэх төлөв байна. (тө: rna ba blogs ni rna ba gtod de/_blo gsal mgrin rgyan las/_rna ba byo ba dang blogs pa ni rna ba gtod pa/_zhes byung /_'di'i rna ba byo ba ni rna ba 'jog pa ste/_phran tshogs las/_sgra de thos pa dang de rnam rna ba byo ste yud tsam bsdad/_ces gsungs pa dang /_yang byo ba ni spo ba'am 'pho ba la yang 'jug ste/_bum pa gang byo'i tshul du/_zhes pa ltar ro/_/'dir blogs zhes pa ni bskul tshig yin no/_/) (Лодан, 3a)

mad pa нь “Лишийн байшин”, “Шинэ, хуучин дохио” хоёуланд нь mad pa нь үнэн хэмээн айлдсан мэт. (тө: mad pa ni/_li shi'i gur khang brda gsar rnying gnyis kar mad pa ni bden pa zhes gsungs pa lta bu'o/_/) (Лодан, 4a) г.м

Мөн уг дохионы тайлбарт “Хүмүүний номын баяр хурим”-ын зарим үгс, түүнтэй холбоо бүхий зарим нэрийг монгол хэлэнд хэрхэн орчуулахыг монгол үгийг төвөд үсгээр тэмдэглэх аргыг ашиглан заасан байна. Үүнд:

Хүснэгт 1: Суртгаал хүмүүний номын баяр хуримын дохионы тайлбар нялхсын хөг найр зохиолд бичигдсэн монгол үгс

№	Төвөд үгс	Дохионы тайлбарт бичигдсэн үгс	Монгол
1	ཕྱི་བརྟོ། (sbyi brtol)	པལ་མང (pal mad)	Балмад
2		མུ་ནའང་ད (mu na'ang da)	Мунайд
3	འཁོབ། ('khob)	བེ་རེ་ཧེ (be re he)	Бээрэх
4	བླས། (blas)	གུ་རུ་ཁུ (gu ru khu)	Гөрөх
5		ནེ་ཁེ་ཁུ (ne khe khu)	Нэхэх
6		སུ་ལུ་ཁུ (sul cu khu)	Сүлжих
7	སློམ (slo ma)	གུ་རུ་སུལ་ཐེབ་ཞི (gu ru mul theb zhi)	Гөрмөл тэвш
8	གླང་མ (glang ma)	ཧ་རུ་ཀ་ས (har pur ka sa)	Хар бургас
9	སྒོར་མོ། (sgor mo)	ཚ་གི་རགས (tsha gi rags)	Цагариг
10	མཚེ (sbre)	ཁེར་ས (kher sa)	Хярс
11	འཇུལ ('thul)	ཧང་ཧལ་ཧ (hang hal ha)	Ханхлах
12	ཤ་མོ (sha mo)	མུ་ཁུ (mu'u gu)	Мөөг
13	ག་ཤེད་འདྲོང (ga shed 'dong)	འེ་ལེ་ལྷ་ལེ ('e le hwa le)	Эл хуль
14		ཧ་མེ་ཀ་ཧོ་ལོ (ha me ka ho lo)	Хаа хол
15		ཐ་ལི་འང་འོད་ཧ (tha li'ang 'od ha)	Талийн одох

16	མཚད་སྐྱམ (mchad sgam)	འབ་ས ('ab sa)	Авс
17	ཤོ་གམ (sho gam)	ཧའི་ལེ (ha'i le)	Гааль
18	ཧོར་འདྲ (hor 'dra)	དར་ཀ (dar ka)	Дарга
19		པོ་ཤོ་ཀ (po sho ka)	Бошго
20	ས་རིམ་འདེད (sa rim 'ded)	འུར་ཐུ་གེ ('ur thu ge)	Өртөө
21	འབོ་རེ ('bo re)	ཇེང (jeng)	Жин
22	སྤེ་པོ (sle po)	འ་རག ('a rag)	Араг
23		སེ་པེག (se peg)	Сэвэг
24	སྤེའུ (sle'u)	སིག་ཟེ (sig ze)	Сэгс
25	སྤེ་བ (sle ba)	ཁི་ལར (khi lar)	Хялар
26	ཚོར་བ (zor ba)	ཧ་དྲ་ར (ha dwa ra)	Хадуур
27	བད (bad)	ཐ་ག་ར་ཚག (tha ga ra tshag)	Таарцаг
28	འཛོར་ཁེམས ('jor khems)	ཚ་རིལ་ཁུར་ཅེ (tsha ril khur tse)	Царил хүрз
29	ཁ་བ (kha bra)	ས་བར (sa bar)	Савар
30	ལ་ནེ (la nye)	བི་ར་ཆེ་དལ (bi ra che dal)	Бяр чадал
31	ཟམ་པ (zam pa)	གུའུ་རུ (gu'u ru)	Гүүр
32	བྲེ (bre)	ཞིང (zhing)	Шин
34	འཇའ་ས ('ja' sa)	ཚ་ཀློ་ཧ (tsa kwa ha)	Жуух
35		འུར་གེམ་ཅེ་ལེལ ('ur gem ce lel)	Өргөмжлөл
36	གྱང (gyang)	ཁེ་རིམ (khe rim)	Хэрэм
37	གྲབ་རྒྱལ་མེད་པ (grab rgyag med pa)	བར་དམ་གའི་འུ་གའི (bar dam ga'i 'u gu'i)	Бардамхай үгүй
38	སྐམ་ཁ (skam kha)	འུ་རུལ་བུ ('u rul bu)	Өрөлбө
39	འབོ ('bo)	འ་ས་ཀ་ཧ ('a sa ka ha)	Асгах
40	ཞེ་མི (she mi)	མི་མོ་ར (mi m+wo ra)	Ми муур
41	འུར་རྫོ ('ur rdo)	དུ་ཀུ་རུ (du ku ru)	Дүүгүүр
42	སྐྱོག་རྫོ (sgyok rdo)	ཅུ་ལུ་ཀ (chu lu ka)	Чулуу

43	གཉི་བོ (gti bo)	འུ་ཤག་འུ་དཀེ ('ur shag 'u da che)	Уршиг удаач
44	འཁང་ར ('khang ra)	ཀོང་སའི་ཧ (kong sa'i ha)	Гонсойх
45		པུག་ས་ཧ (pug sa ha)	Бугсах
46		ཐུ་ནི་ཧ (thu ni ha)	Туних
47	སྐྱེ (sgye)	འུ་ཐ ('u tha)	Уут
48	ཕད (phad)	ཐ་ཀ་ར་ཚག (tha ka ra tshag)	Таарцаг
49	སིང་པོ (sing po)	ད་ར་ས (da ra sa)	Дарс
50	ལྷ་བ་མོ (lha ba mo)	ཡུ་ཏ་ཀྱང (u ta kwan)	Удган
51	ཐུལ་བ (thul ba)	ད་ཧ (da ha)	Дах
52	གོང་བ་རལ་ན (gong ba ral na)	ཙ་ཧ་ནི་འུ་རག་ད་ཧ (tsa ha ni 'u rag da ha)	Зах нь урагдах
53	ཕྱགས་མ (phyags ma)	ཤེར་བུ་ལུ (sher bu lu)	Ширвүүл
54	དོར་མ (dor ma)	འུ་མུ་དུ ('u mu du)	Өмд
55	མཚོལ་བུ (mdzol bu)	འུ་ར་ཧ ('+wa ra ha)	Урхи
56		ཧལ་ཧ (hab ha)	Хавх
57		ཙང་ཀ (tsang ka)	Занга
58	རྩི (rnyi)	འུ་ཀུ་ཤེ ('u ku she)	Өгөөш
59		འུ་རེ་ནི ('u re hi)	Урхи
60	ཤུ་ཐོར (shu thor)	ནམ་ས (nam sa)	Намс
61		ནི་སྤ་ཀོ (ni swa ko)	Нөсөө
62	ཤ་བཀྲ (sha bkra)	འ་ལག་མ་ར་ཡ ('a lag ma ra ya)	Алаг мариа
63		ཚ་ཧ་ལའི (tsha ha la'i)	Цахлай
64	སྐད་འཆལ (smad 'chal)	པུག་སུ་ནི་འོ་རོང་གེ (pug su ni 'o rong ge)	Бөгс нь оронги
65	ཐུ་གུ (gru gu)	ཐུ་དེག (thu deg)	Түүдэг
66	མ་གལ (ma gal)	འུ་ལེ་ཡ་ས ('u le ya sa)	Улиас
67	ལྷ་ལྷོ (kla klo)	ཐེར་སེ་ཀུ་དུ (ther su ku du)	Тэрсүүд
68	ཡ་རུ (ya ru)	ཤེ་རུ་ལིང་། (shu de leng)	Шүдлэн
69	སྲིད་གསལ (srid gsal)	ཐུ་རུ་གེ་རིལ་ཐུ (thu ru ge ril thu)	Төргэрэлт

Буддын шашны хүчтэй дэлгэрэлт, төвөд хэл бичгийн өргөн тархалтын улмаас тодорхой хүрээ хэмжээнд алба, амины бичиг монгол бичгийг төвөд үсгээр галиглан бичих тохиолдол байсан байна. Энэ байдлыг “... төвөд хэл бараг газар болгонд монголчуудын буддын сүм хийдийн хэл, буурьтай утга зохиолын хэл, оюун санааны дээд амьдралтай холбогдсон дээд бүх юмны дээд хэл болж байв” (Владимирцов, 1929: 27) хэмээсэн байна.

Олон улсын монголч эрдэмтдийн анхдугаар хуралд Т.Пагва “Төвд үсгээр үгчилсэн монгол зохиол” хэмээх илтгэл хэлэлцүүлж түүндээ Гэлэгбалсангийн “Наадмын ерөөл” болон “Молон тойны намтар зохиол”-оос хэсэглэн авч төвөд үсгээр монгол хэлээр хэрхэн бичиж байсан байдлыг үзүүлээд монгол хэлний авиалбарыг төвөд үсгээр дүйлгэн тэмдэглэж үгчлэх зарчмын ерөнхий тойм, онцлогийг тодорхойлон дурджээ. (Шагдарсүрэн нар, 2022: 229)

Хүснэгт 2: Суртгаал хүмүүний номын баяр хуримын дохионы тайлбар нялхсын хөг найр зохиолд бичигдсэн Хятад үгс

№	Төвөд үгс	Дохионы тайлбар бичигдсэн үгс	Хятад дуудлага	Утга
1	ལྷོགས (khyogs)	ལྷོ་ཙ (kyA+o tsa)	Jiao zi	Жууз
2	སློམ (slo ma)	ཕའོ་ལུ (pha'o lu)	Pao lu	Поолуу
3	ཤོགས (sho gam)	ཤུ (shu'u)	Shui	Гааль
4	འཛོར་ཁེམས (‘jor khems)	ཀཤུ (ka phu)	x	Царил хүрз
5	ཕུགས་མ (phyags ma)	སྟོ་ལྷོ (swo kyo'u)	sào zhou	Ширвүүл

5. Дүгнэлт

“Хүмүүний номын баяр хурим” хэмээх зохиол нь яруу найраг, эвсүүлэн найруулах арга зэргийн ашиглан 100 шүлэг буюу 400 мөр, нэг мөрөнд 9 үеэр (тө: tseg bar) жигдлэн шүлэглэсэн сургаалын зохиол ба энэхүү зохиол нь бидний тооцоолж гаргаснаар төгсгөлийн үгтэйгээ нийлээд 3916 үеэс бүрдэх бөгөөд нийт давхардсан тоогоор 2557, давхардаагүй тоогоор 2000 орчим үгээс бүрдэж байна.

Лодан нэрт эрдэмтний “Суртгаал хүмүүний номын баяр хуримын дохионы тайлбар нялхсын хөг найр” (тө: blabs bya mi chos dga’ ston gyi brda’ bkrol byis ba’i rol rdzod ces bya ba) зохиол нь бар хэвлэл болон гар бичмэл хэд хэдэн хувилбараар Гандантэгчэнлин хийд болон Үндэсний төв номын сан, BDRC цахим номын сангийн сан хөмрөгт эх хувь болон хуулбараар хадгалагдаж байна.

Тус зохиолд “Хүмүүний номын баяр хурим” зохиолын 600 орчим бэрх үгийг Энэтхэг, Төвөд, Монголын олон эрдэмтэн лам нарын бүтээл, туурвил болон аман дамжлагаас эшлэн тайлбар бичсэн байна. Нэн ялангуяа “Хүмүүний номын баяр хурим” зохиолын зохиогч Алшаа Агваандандар лхаарамбын толь бичиг, хэл шинжлэлийн бүтээлүүдээс эшлэл татсан байгаа нь уг бүтээл дээр Агваандандар лхаарамбын таалал, оноосон нэр томъёотой таарах магадлалыг нэмж байна.

Уг зохиолоос үзвэл Лодан нэрт нь Чин сүзэгт номун ханы гуравдугаар дүр Лувсанжигмэдданбийжалцан (1829-1882)-ы шавь нарын нэг бөгөөд XIX зууны үеийн хүн бөгөөд Баянхонгор аймгийн Галуут сум Чин сүзэгтийн хүрээнд шавилан, амьдарч байсан байх магадлалтай. Мөн уг зохиолдоо энэтхэг, төвөд, монголын тавин зургаан бүтээлээс эшлэл аван “Хүмүүний номын баяр хурим”-ын бэрх үгийг тайлбарлахдаа бусад зохиолд хэрхэн ашиглагдсан,

бусад үгийн тайлбарт хэрхэн тайлбарласан зэргээр тайлбараа баяжуулсан ба төвөд, монгол хэлтэй эрдэмтэй хүмүүн байсан байна.

Ном зүй:

- Агваанчойдор**, (2009). *Алшаагийн Агваандандар лхаарамба “Хүмүүний номын баяр хурим”*, Хэл бичиг, утга соёл эрдэм шинжилгээний бичиг №5 (4), УБ, х.130-137 [Agwaanchoidor, *Alshagiin Agwaandandar lhaaramba “Humuunii nomiin bayar hurim”*] [Journal of Language, Literature, and Cultural Studies, No. 5 (4).] Ulaanbaatar, 2009.]
- Бямбаа. Р.**, (2004). *Монголчуудын төвд хэлээр туурвисан монгол хэлэнд орчуулсан ном зүйн бүртгэл II боть*, УБ [Bumbaa, R., *Mongolchudiin tuvд heleer tuurvisan mongol helend orchuulsan nom zuin burtgel II boti*, [A bibliography of books written in Tibetan and translated into Mongolian by Mongolians.] Ulaanbaatar, 2004.]
- Владимирцов. Б.Я** (1929). Сравнительная грамматика монгольского письменного языка и халхасского наречия. *Введение и фонетика*.
- Гомбожав. С.**, (1961). *Монголчуудын төвөд хэлээр бичсэн зохиолын зүйл*. УБ. [Gombojav. S., *Mongolchuudyn tuvud heleer bichsen zohioliin zuil*, [Literary works in Tibetan by Mongols] Ulaanbaatar, 1961.]
- Лодан**, (n.d.). Хүмүүний номын баяр хуримын дохионы тайлбар нялхасын хөг найр (тө: bsלב bya mi chos dga' ston gyi brda' bkrol byis ba'i rol rdzod).
- Шагдарсүрэн. Ц, Даваасүрэн. Б.**, (2022). *Монгол хэл судлал VII Боть Үсэг зүй*. УБ. [Shagdarsuren. Ts, Davaasuren. B., Gombojav. S., *Mongol hel sudlal VII boti Useg zui*, [Study of Mongolian Language, Volume VII: Orthography] Ulaanbaatar, 2022.]



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>